

БНСУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭТГЭЛЭГ

Хөтөлбөрийн товч танилцуулга

БНСУ-ын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр нь гадаадын шилдэг, авьяаслаг оюутан залуусыг Солонгос улсад дээд боловсролын байгууллагад өндөр төвшний хөтөлбөрт суралцах боломжийг олгох хөтөлбөр санал болгох замаар дэлхийн ирээдүйн манлайлагч нарыг дэмжих, олон улсын боловсролын хамтын ажиллагааг хөгжүүлэх хөтөлбөр болно.

Шалгуур үзүүлэлт

- Ахисан төвшний хөтөлбөр (Хугацаа: Жил бүрийн өмнөх оны 9-р сар)

Тэтгэлгийн хугацаа	Магистрын зэрэг	1 жилийн Хэлний бэлтгэл + 2 жилийн Зэргийн хичээл
	Докторын зэрэг	1 жилийн Хэлний бэлтгэл + 3 жилийн Зэргийн хичээл
Шалгуур үзүүлэлт	<ol style="list-style-type: none">Тухайн сонгон шалгаруулалтын жилд жагсаалтанд орсон гадаад улсын иргэн байх ёстой. * Хоёр улсын иргэншилтэй БНСУ-ын иргэн эсвэл БНСУ-ын иргэн энэ хөтөлбөрд оролцох эрх байхгүй.Сонгон шалгаруулалтанд оролцогч нь тухайн элсэн орох хичээлийн жилийн есдүгээр сарын нэгний өдөр гэхэд 40-өөс доош настай байх ёстой. Гэхдээ доор бичсэн бүх шалгуурыг хангасан байх ёстой:<ul style="list-style-type: none">Хөгжлийн буцалтгүй түслэмж авдаг орны иргэн байх ёстой.Элсэн орох хичээлийн жилд 45-аас доош настай байх ёстой.Сонгон шалгаруулалтанд оролцогч нь элсэн орох хичээлийн жилийн есдүгээр сарын нэгний өдөр гэхэд бакалавр эсвэл магистрын зэрэг авсан байх ёстой. * БНСУ-д бакалавр, магистр, докторын хөтөлбөр дүүргэсэн хүн сонгон шалгаруулалтанд орох эрхгүй.	

- Бакалаврын хөтөлбөр(Хугацаа: Жил бүрийн 2 дугаар сар)

Тэтгэлгийн хугацаа	Бакалаврын зэрэг	1 жилийн Хэлний бэлтгэл + 4 жилийн Зэргийн хичээл
	Зэргийн бүс хөтөлбөр	1 жилийн Хэлний бэлтгэл + 2 эсвэл 3 жилийн Зэргийн бус хичээл * Тухайн жилийн эхний улиралаас, 3-жилийн зэргийн бүс хөтөлбөрт оролцох эрхтэй.

Шалгуур үзүүлэлт

Сонгон шалгаруулалтанд оролцох хүн нь доор бичсэн шалгууруудыг хангах ёстой;

1. Сонгон шалгаруулалтын уралдаант шалгалтанд оролцогчийн эцэг эх нь тухайн сонгон шалгаруулалтын жилийн гарын авлагын жагсаалтанд орсон улсын иргэн байх ёстой.
* Хоёр улсын иргэншилтэй БНСУ-ын иргэн эсвэл БНСУ-ын иргэн энэ хөтөлбөрд оролцох эрх байхгүй .
2. Элсэн орох жилийн Гуравдугаар сарын нэгний өдөр гэхэд сонгон шалгаруулалтанд оролцогч нь ахлах сургуулиа төгссөн байх ёстой.
3. (Бакалаварын хөтөлбөр) Ахлах сургуулийн нийт голч дүн нь 100 хувийн онооноос 80 хувь хүрсэн эсвэл түүнээс дээш хувь авсан байх ёстой.
4. (Зэргийн бус хөтөлбөр) Ахлах сургуулийн нийт голч дүн нь 100 хувийн онооноос 75 хувь хүрсэн эсвэл түүнээс дээш хувь авсан байх ёстой.
5. Сонгон шалгаруулалтанд оролцогч нь тухайн элсэн орох жилийн гуравдугаар сарын нэгний өдөр гэхэд 25 наснаас доош настай байх ёстой.

Сонгон шалгаруулалтын үйл явц

1



Сонгон
шалгаруулалтын
материал өгөхд;
1-р шалгаруулалт
хийх

2



Үнэлгээний хороо
2-р шалгаруулалт
хийнэ

3



2-р шалгаруулалтыг
их сургууль хийнэ



Шалгаруулалтын
эцсийн дүн гарах

Дэлгэрэнгүй мэдээллийг авах бол

- http://www.studyinkorea.go.kr/mn/sub/gks/allnew_invite.do